



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/330

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Очирбат овогтой Баасан (ЦГ66100211)-ын Мөрөн сум 5 дугаар баг Зах "Тээврийн товчооны хашаа" хаягт байршилтай 6712016024 нэгж талбарын дугаартай 8836м² худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлсэн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул өөрийнх нь хүсэлтийн дагуу 7 жилийн хугацаагаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/386 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч О.Баасантай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР

